



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан 542,365,308.00 (таван зуун дөчин хоёр сая гурван зуун жаран таван мянга гурван зуун найман) төгрөгийн үнэ бүхий Авто засварын дадлагын барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Баянхонгор аймгийн Политехникийн коллежид эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн захирал Д.Бат-Орших нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төслийн санхүүжилтээр бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, бүртгэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

д.НАРАНГЭРЭЛ

13201003



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Барилтын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Авто засварын дадлагын барилга, байгууламж, /Баянхонгор аймаг Рашаант 10-р баг Таван Эрдэнэ-1/	1 давхар, зоопрүй, 312M2	542,365,308.00	2020-07-23 2020/22
	<b>Нийт дүн</b>		<b>542,365,308.00</b>	<i>/таван зуун дөчин хоёр сая турван зуун жаран таван мянга гурван зуун найман/</i>